



Дотоод хэргийн их сургуулийн захирлын 202...
оны ... дугаар сарын ... өдрийн дугаар
тушаалын хавсралт

Баримт бичгийн код:

Ж.203-13

Журмын нэр:

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Хувилбар №:

01

ЖУРМЫН БАТАЛГААЖИЛТ				
Үүрэг	Нэр, цол	Албан тушаал	Гарын үсэг	Огноо
Санаачилсан:	ISO нэвтрүүлэх ажлын хэсэг			
Боловсруулсан :	Цагдаагийн ахлах дэслэгч Б.Хулан	Хувийн эрх зүйн тэнхимийн багш		2021.06
Санал өгсөн:	Хурандаа В.Жавхланцогт	Сургалтын бодлого, төлөвлөлтийн газрын дарга		2021.06
Хянасан:	Цагдаагийн хурандаа Д.Эрдэнэбаатар	Сургалт эрхэлсэн дэд захирал		2021.06

ЖУРМЫН ХЯНАЛТ		
ЭХ ХУВЬ	ХУУЛБАР ХУВЬ	ХҮЧИНГҮЙ ХУВЬ
Тэмдэг/дардас	Тэмдэг/дардас	Тэмдэг/дардас
Журмын төсөл боловсруулалтын эцэслэсэн файлын цахим сангийн байршил: PC ID: d/juram2021/203-13		
Огноо:	Огноо:	Огноо:
Гарын үсэг:	Гарын үсэг:	Гарын үсэг:

Энэхүү баримт бичиг нь Дотоод Хэргийн Их Сургуулийн **ӨМЧ** бөгөөд зөвшөөрөлгүй хуулбарлах, олшруулах, түгээхийг хориглоно!!!

Баримт бичгийн код:	Хувилбар №	Баталсан огноо:	Тушаалын дугаар:
Ж.203-13	01		

ТОВЬЁГ

1.	Хавсралтын жагсаалт.....	3
2.	Өөрчлөлтийн тэмдэглэл.....	3
3.	Үндэслэл	3
4.	Зорилго	3
5.	Хамрах хүрээ	3
6.	Нэр томъёо	3
6.1.	Нэр томъёоны тодорхойлолт.....	3
6.2.	Товчилсон үгийн тайлбар	3
7.	Шаардлага	3
8.	Үйл явцын зураглал.....	5
10.	Түгээлтийн тэмдэглэл	8
11.	Танилцаж, зөвшөөрсөн тэмдэглэл.....	8

Баримт бичгийн код:	Хувилбар №	Баталсан огноо:	Тушаалын дугаар:
Ж.203-13	01		

1. Хавсралтын жагсаалт

№	Хавсралтын нэр	Баримт бичгийн код
1		
2		

2. Өөрчлөлтийн тэмдэглэл

№	Заалт	Өөрчлөлтийн бичилт	Шалтгаан	Баталгаажилт
1				
2				

3. Үндэслэл

Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Боловсролын тухай хуулийг үндэслэв.

4. Зорилго

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тодорхой чиглэлээр мэргэшүүлэх зорилгоор сургалт зохион байгуулах дэг горимыг тогтооно.

5. Хамрах хүрээ

Дотоод хэргийн их сургуулийн бие бүрэлдэхүүн, их сургуулийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан зөвлөл хамаарна.

6. Нэр томьёо

6.1. Нэр томьёоны тодорхойлолт

Мэдлэг, ур чадвар нэмэгдүүлэх сургалт - 1-3 кредит цагийн сургалтыг;

Мэргэшүүлэх сургалт - 3 кредитээс 8 цагийн сургалтыг;

Хэрэглэгч байгууллага - Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудыг.

6.2. Товчилсон үгийн тайлбар

ХЗДХЯ – Хууль зүй, дотоод хэргийн яам

ГХУСАЗЗ – Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл

ДХИС - Дотоод хэргийн их сургууль

ЭШНХ – Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн

СБТГ – Сургалтын бодлого, төлөвлөлтийн газар

ЦС – Цагдаагийн сургууль

ЭЭЗКТ – Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим

7. Шаардлага

7.1. Бэлтгэл үе

7.1.1. ГХУСАЗЗ-ийн ажлын албанаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын талаар санал авч Их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийн ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгана.

Баримт бичгийн код:	Хувилбар №	Баталсан огноо:	Тушаалын дугаар:
Ж.203-13	01		

7.1.2. Захиалагч байгууллагуудын хүсэлтийг үндэслэн шаардлагатай тохиолдолд мэдлэг, ур чадвар олгох, дээшлүүлэх түр сургалтыг хугацаа харгалзахгүй, тухайн байгууллагын хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулж болно.

7.1.3. Төлөвлөгдсөн сургалтын хөтөлбөр, танилцуулга, үргэлжлэх хугацааг урьдчилан захиалагч байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

7.1.4. Мэргэшүүлэх сургалтад хамрагдах ажилтан, албан хаагчдын нэрсийн жагсаалтыг ГХУСАЗЗ-ийн ажлын албанаас ирүүлсэн албан бичиг, хавсралт /нэрсийн жагсаалт/-ыг үндэслэн Их сургуулийн захирлын тушаалаар суралцуулна.

7.1.5. “Цагдаа-гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил” бакалаврын мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт үндэслэн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх хичээлийн хөтөлбөрийг батлуулна.

7.2. Сургалтын үе

7.2.1. Мэргэшүүлэх сургалтын багц цагийн 60-аас дээш хувийг хангасан суралцагчдад сертификат гардуулах эрх нээгдэнэ.

7.2.2. Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1-17.3 дахь хэсэгт заасныг зөрчихгүйгээр захиалагч байгууллага нь Их сургуультай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх зорилгоор /ном, сурах бичиг, техник хэрэгсэл/ дэмжлэг үзүүлж болно.

7.3. Үр дүнг үнэлэх үе

7.3.1. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй бүрэлдэхүүн сургууль мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтын явц, үр дүнг сургалт эрхэлсэн дэд захиралд илтгэх хуудсаар танилцуулна.

Баримт бичгийн код:	Хувилбар №	Баталсан огноо:	Тушаалын дугаар:
Ж.203-13	01		


8. Үйл явцын зураглал

8.1. SIPOC диаграм

ББ код:	SIPOC диаграммын нэр:			ББ хувилбар:
SD.203-13	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах			1
Suppliers	Inputs	Process	Outputs	Customers
Хангагчид	Оролтууд	Үйл явц	Гаралтууд	Хэрэглэгчид
Их сургуулийн захирал	Боловсролын тухай хууль	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах	-Санал хүргүүлэх тухай албан бичиг, хариу; -Хичээлийн хөтөлбөр; -Төлөвлөгөө; -Сургалтад оролцогчдын нэрс; -Сертификат.	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагчид
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль			
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хөтөлбөр, төлөвлөгөө			
	Хичээлийн жилийн сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийн ажлын нэгдсэн төлөвлөгөө, Их сургуулийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө			
	"Цагдаа-гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил" сургалтын хөтөлбөр			
Сургалт эрхэлсэн дэд захирал	ДХИС-ийн дүрэм			
Сургалтын бодлого төлөвлөлтийн газар	ДХИС-ийн дотоод журам			
Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн	ДХИС-ийн суралцагчийн мэдлэг чадварыг үнэлэх журам			
Цагдаагийн сургууль	Их сургуулийн үйл ажиллагааны журам боловсруулах түүнийг мөрдөх журам			

Баримт бичгийн код:	Хувилбар №	Баталсан огноо:	Тушаалын дугаар:
Ж.203-13	01		

8.2. Cross Functional Flow Chart диаграм



Баримт бичгийн код:	Хувилбар №	Баталсан огноо:	Тушаалын дугаар:
Ж.203-13	01		

9. Үйл явц

9.1. Бэлтгэл ажил хангах үе

9.1.1 ГХУСАЗЗ-өөс санал хүлээн авах:

Цагдаагийн сургууль зохион байгуулах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан чиглэлээр захиалагч байгууллагад зохион байгуулах мэдлэг, ур чадвар дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтын давтамж, хугацааны талаар саналыг цуглуулна.

9.1.2 Хичээлийн жилийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгах:

Цагдаагийн сургууль сургалт зохион байгуулах хугацааг тухайн хичээлийн жилийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд тусгана.

Санамж: Сургалтын бодлого төлөвлөлтийн газар хамтран ажиллана.

9.1.3 Хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах:

Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим мэдлэг, ур чадвар дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтын болон хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулна.

Санамж: “Цагдаа-гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил” бакалаврын мэргэшүүлэх хөтөлбөрт үндэслэнэ.

9.1.4 Сайжруулалт хийх шаардлагатай эсэх:

Цагдаагийн сургууль сургалтын хөтөлбөрийн төсөлд дүн шинжилгээ хийж сайжруулах шаардлагатай бол 9.1.5-т зааснаар, батлуулах бол 9.1.6-т зааснаар тус тус зохицуулна.

9.1.5 Сайжруулалт хийх:

Цагдаагийн сургууль сургалтын хөтөлбөрийн сайжруулалт хийх ажлыг зохион байгуулна.

9.1.6 Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлах:

Сургалтын болон хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөг Их сургуулийн сургалт эрхэлсэн дэд захиралд танилцуулж, батлуулна.

9.1.7 Мэргэшүүлэх сургалтад суралцах нэрс гаргах:

Кредит цагийг хангасан эсэхийг илэрхийлэх сертификат олгох тул нэрсийн жагсаалтыг авна.

Санамж: Мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтын тухайд сертификат олгохгүй.

9.1.8 Сертификат хэвлүүлэх захиалга өгөх:

Их сургуулийн ЭШНХ-ийн Хэвлэл, редакцын хэлтэст нэрсийн жагсаалт, загварын хамт сертификатын захиалгыг хүргүүлнэ.

9.2. Сургалтын үе шат:

9.2.1. Сургалт эхлэх:

Баталсан хөтөлбөр, төлөвлөгөө, хуваарийн дагуу сургалтыг эхлүүлнэ.

9.2.2. Явцын хяналт тавих:

Цагдаагийн сургуулийн захирал сургалтын үйл явц технологийн дагуу явагдаж буй эсэхийг хянана.

9.2.3 Сургалтын талаар санал, асуулга авах:

Сургалтад оролцогчдоос сургалтын хэрэгцээг нэмэгдүүлэх, хичээлийн хөтөлбөрийн агуулгын чанар, хүртээмж, үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор санал, асуулга авч нэгтгэнэ.

9.3. Үр дүнг үнэлэх үе

Баримт бичгийн код:	Хувилбар №	Баталсан огноо:	Тушаалын дугаар:
Ж.203-13	01		

9.3.1 **Сертификат хүлээн авах:**

Мэргэшүүлэх сургалт зохион байгуулсны дараа Хэвлэл, редакцын хэлтсээс нэрсийн жагсаалттай тулгалт хийж сертификатыг хүлээн авна.

9.3.2 **Сертификат батлах:**

Мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамрагдаж багц цаг хангасныг баталгаажуулах сертификатыг Их сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирлаар батлуулна.

9.3.3 **Сертификат гардуулах:**

Цагдаагийн сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч сертификат гардуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

9.3.4 **Сургалтын явц үр дүнгийн илтгэх хуудас боловсруулах:**

Сургалт зохион байгуулсан нэгж сургалтын үйл явц, санал, асуулгын үр дүнг нэгтгэн Илтгэх хуудас боловсруулна.

9.3.5 **Илтгэх хуудсаар танилцуулах:**

Илтгэх хуудсыг цагдаагийн сургуулийн захирлаар уламжлан сургалт эрхэлсэн дэд захиралд танилцуулна.

9.3.6 **Илтгэх хуудас хүлээн авах:**

Сургалт эрхэлсэн дэд захиралд танилцуулсан илтгэх хуудсыг хүлээн авч, өгсөн үүрэг чиглэлийн дагуу ажиллах, илтгэх хуудсыг нэгтгэн сан үүсгэнэ.

9.3.7 **Сургалт зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн Их сургуулийн үйл ажиллагааны тайлан, мэдээнд хүргүүлэх:**

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг, ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалт зохион байгуулсан талаарх үр дүнг тухай бүрд Их сургуулийн үйл ажиллагааны тайлан, мэдээнд хүргүүлнэ.

10. Түгээлтийн тэмдэглэл

№	Бүрэлдэхүүн сургууль, институт, бүтцийн нэгж	Шифр №	Түгээсэн огноо	Гарын үсэг	Буцаан татсан огноо
1					
2					

11. Танилцаж, зөвшөөрсөн тэмдэглэл

№	Ажилтны нэр	Албан тушаал	Огноо	Гарын үсэг
1				
2				